

Улсын хурал ба эрдэмтэн Дандаа
(Сурвалжийг нягтлахуй)

Доктор /PhD/, профессор З.Лонжид

Монголын нэрт эрдэмтэн, гүүш Чимидийн Дэмчигдорж(1863-1932) буюу өргөн олонд цахар түшмэл Дандаа хэмээн алдаршсан өвөрлөгч гаралтай энэ их хүн 1911 онд сэргээн тунхагласан Монголынхоо төрийг төвшигтгөж, улс гэрээ засах их үйлсийн төлөө чигч шударгаар үнэнхүү чармайн хичээдэг байлаа. Тэрбээр 1911 оноос хойш Нийслэл Хүрээнд ирж Богд эзний соёрхлоор өөрийн эзэмшил газар нутагтай эрхэлсэн ажилтай болж, Монголоо хөгжүүлэх их үйлсэд насан хутаг болтлоо хүчин зүтгэж сэтгэлээ чилээсэн юм. 1915 оны хавар Хаант Орос, ДИУ хоёр ил ба эчнээ хуйвалдсаар манай Монголын тусгаар тогтнолыг хүчээр цуцлаж, Хятадын автономит улс болгосны дараа өвөрлөгч гаралтай ноёдын олонхи нь Өвөр Монгол руугаа буцсан бол эрдэмтэн түшмэл Дандаа уугуул нутаг Цахар луугаа огтхон ч явалгүй Нийслэл Хүрээнд үлдэж, эрдэм судлал, орчуулгын цаг завгүй их ажилдаа шимтэж бүтээлээ туурвисаар байсан нь тэрбээр монголдоо хэр зэрэг элэгтэй хүн байсны нотолгоо мөн нь ер маргаангүй билээ.

Энэ их эрдэмтний тухай манай монгол ба бусад улсын судлаачид бүээл туурвилдаа олонтаа өгүүлсэн байдгийн сацуу 1990 оноос хойш түүний зарим бүтээлийг эрдэмтэн Д.Дашбадрах кирилл бичигт буулган хоёр удаа хэвлүүлсэнийг ухаалаг сэхээтнүүд, түүх сонирхон судлаачид уншиж судалсаар байна.

Эрдэмтэн Дандаа шинэ Монгол улсаа хөгжүүлэх хамгийн чухал зүйл бол зөвхөн эд агуурс хөрөнгө баялаг бус хүн зон нь унасан газар угаасан ус орон дэлхийгээ дээдлэн шүтдэг гэгээрсэн ухаалаг, чин шударга арвич хямгач, тусч энэрэнгүй, нягт хичээнгүй өөдрөг сэтгэлтэй байж эх түүх, үеэс үед уламжилж ирсэн зан үйлээ сайтар мэддэг түүнийхээ эерэг нааштайгаас өвлөн суралцаж сөрөг бурангуйг нь давтахаас ямагт зайлсхийж чаддаг байх явдал мөн хэмээн тууштай үздэг байсан аж. Тэрбээр өөрийнхөө цуврал бүтээлүүддээ чухам ийм л үзэл бодлоо номлож, хэн хүний ухаарч мэдэхэд тус хүргэхийг чин санаанаасаа хүссэн нь илэрхий мэдэгдэнэ.

Дандаа өөрийнхөө бүтээлийг зөвхөн хаад ноёд төрийн түшээдэд буюу ихэс дээдэс эрхтэн дархтанд зориулж бус нийгмийн аль ч давхрааны хэн боловч уншаад өөрийнхөө амь зуулга ажил төрөл болж бүтэж буй эсэхийг эрх биш эргэцүүлэн нягталж нэгийг бодож нөгөөг сэтгэж байгаасай хэмээсэн голч чиг шугамыг хатуу баримталдаг эрдэмтэн хүн байсан нь түүний бүтээлийг уншсан хэнд ч ойлгогдохуйц байдаг билээ. Ер нь тэрбээр зохиол бүтээлээ туйлын энгийн хялбар бөгөөд сонгодог найруулгыг ардын ярианы хэлбэртэй хослуулан бичдэг байсан нь ямар ч хүн унших ухаж ойлгоход үнэхээр дөт байсан аж.

Дандаагийн бүх бүтээлийн <<амин сүнс>> бол тэрбээр Монгол улсаа тухайн үед ба ирээдүйд хэрхэн хөгжүүлэхэд зайлшгүй анхаарууштай олон зүйл сэдэв дэвшүүлж, тэдгээрийг бодитой хэрэгжүүлэх арга замыг хэн боловч хялбархан ухаарахуйц хэл найруулгатай бичсэн байдгаараа тухайн үеийнхээ эрдэм номтой түшмэд бичгийн хүмүүсээс онцгой содон юм.

Дандаа өөрөө бүтээл туурвихын сацуу дорно дахины олон улсын хэл бичигт гаргууд нэвтэрсэн эрдэмтэн хүнийхээ хувьд япон, хятад хэлээр хэвлэгдэн түүх шастир, хууль цааз, аж ахуй эдийн засаг, соёлын холбогдолтой олон бүтээл уншиж, улс Монголдоо хэрэгтэй зүйл юу байгааг олж мэдэхийг байнга шимтдэг хүн байлаа. Тиймээс ч тэрбээр Мин улсын анхны эзэн хаан Чжу Юан жан (1368-1398)- гийн зарлигаар 1369-1370 онд Сүн Лян, Ван Вей тэргүүтэй хэсэг түүхч эрдэмтний орчуулж хэвлүүлсэн 210 боть <<Юан ши>> буюу <<Юан улсын судар>>-ыг монголчилсон нь түүний хир зэрэг чадвартай гүүш болохыг илэрхий нотолж байдаг.

Энэ үлэмж том бүтээлийг тэрбээр яагаад орчуулах болсон тухай цухас тэмдэглэх нь илүүц бус билээ.

Монгол улсын ГХБЭШЯ-ны дэд сайд бөгөөд Сайн ноён хан амгийн засаг ноён Далай Чойнхор ван Г.Цэдэнсоном, эрдэмт түшмэл Жамсрангийн Цэвээн нараас Улсын хуралд санал өргөж <<Юан улсын судар>>-ыг монголоор орчуулан олны хүртээл болгохыг хүссэн байна. Улсын хурал тэдний саналыг сайшаан тухайн үед Нийслэл Хүрээнд сууж байсан түшмэл Дандааг урьж энэ тухай санал болгоход тэрбээр дуртайяа зөвшөөрч орчуулуулахаар тохиролцжээ. Ингээд Дандаа 1917 оноос эхлэн <<Юан улсын судар>>-ыг орчуулсан боловч энэ хооронд Монгол оронд улс төрийн хямрал нүүрлэж хэд хэдэн төр солигдсон аж. Гэвч тэрбээр долоон жилийн турш уг номыг тасралтгүй орчуулсаар 1923 онд дуусгаж, Монгол улсын Судар бичгийн хүрээлэнгийн эрхэлсэн түшмэл бөгөөд эрдэмтэн нарийн бичгийн дарга, анх уг ажлыг сэдэлцсэн Ж.Цэвээнд хүлээлгэн өгсөн байна. Дэлхийн олон орны монгол судлаач эрдэмтдийн анхаарлыг татахуйц мэдээ бүхий энэхүү бүтээлийг Дандаа орчуулсан нь манай түүх судлалд тодорхой ахиц гарах монголчууд эх түүхээ таньж мэдэхэд зохих нөлөө үзүүлсэн билээ.

Эдүгээгээс наян жилийн тэртээ эрдэмтэн гүүш Дандаагийн орчуулсан <<Юан улсын судар>>-ыг манай монголын түүхчид байнга ашиглаж, зохиол бүтээлээ туурвихад гол тулгуур эш хэрэглэгдэхүүн болгосоор байдаг. Гэвч тэр орчуулга нь Улаанбаатар хотноо Улсын төв номын санд ердөө ганц хувь байдаг нь хүссэн хүн бүхнийг үзэж судлахад багагүй төвөгтэйг хөнгөвчлөх үүднээс 2002 онд хэсэг залуу судлаач зориглон тэрхүү зохиолын эхний хэдэн дэвтрийг кирилл бичгээр хэвлэж орчуулгын анхны эхийг нь цахилгаан бар (факсимиле)- аар хуулан хавсаргасан нь тун сайшаалтай.

Энд бас нэгэн зүйлийг цухас тэмдэглэж урьд өмнө нь сонсож мэдээгүй хүмүүст сонин болгон сонордуулъя. Юу гэвээс: Хаант Оросын үнэн алдартны шашны элчээр хятад нутагт сууж байсан П.И. Каменский(1765-1845) <<Юан улсын судар>>-ыг манж хэлнээс орос хэл рүү орчуулж өөр хэд хэдэн орчуулгын бүтээлтэйгээ Оросын дипломат Ю.А.Головкинийг 1805 онд Бээжинд очиход өргөн барихаар бэлтгэж байсан тухай 1996 оны хавар Бүх оросын баримт бичиг судлал, архивын хэргийн шинжилгээ судалгааны хүрээлэнгээс зохион байгуулсан эрдэм шинжилгээний хуралд Оросын Холбооны Улсын ШУА-ийн Дорно дахины судлалын хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ахлах ажилтан түүхийн ухааны дэд эрдэмтэн А.Н.Хохлов мэдээлсэн байна. (*Архивоведение и источниковедение отечественной истории. Проблемы взаимодействия на современном этапе. Доклады и тезисы выступлений на второй Всероссийской конференции. 12 -13 марта 1996 г. М. 1997. стр. 288-д үз*)

Эрдэмтэн А.Н. Хохловын энэ мэдээлэлээс үзвэл Оросын шашны элч П.И.Каменский хэмээгч <<Юан улсын судар>>-ыг орчуулсан нь тодорхой байна. Гэтэл тэрхүү орчуулга одоо чухам хаана хадгалагдаж буй ба судлаачид түүнийг ашигладаг эсэх нь тун бүдэг байгааг манай түүхчид цаашид мөшгөн нягтлууштай.

Дандаа бол үнэхээр төрийн мэргэн түшээ, ухаан төгс эрдэмтэн байсан нь түүний бүтээл туурвилуудаар тодорхойлогдохын сацуу тэрбээр монгол улсаа төвшитгөн тохинуулахын тулд санаа тавин хичээн чармайж оюун бодлоо шавхан сэтгэдэг эгэл бус сод нэгэн байсныг Улсын хуралд түүний удаа дараалан өргөсөн санал бодролуудаас нь мэдэх боломжтой.

Эрдэмтэн Дандаа Улсын хуралд өргөн толилуулсан гурван саналыг Үндэсний төв архивын түүхийн баримтын төвийн I-р фонд буюу Улсын хурлын сан хөмрөгт хадгалж байна. Гэвч түүний саналыг манай судлаачид эдүгээ хүртэл ашиглаагүй буюу шинжилгээний эргэлтэд оруулаагүй байгааг харгалзаж энэ тухай түүхчдэд сонирхуулах үүднээс энэхүү хураангуй зүйлийг тэрлэлээ.

Дандаа Монгол Улсын Засгийн газарт зөвлөх түшмэлээр томилогдон ажиллаж байсан учраас улс орны өмнө нэн тулгамдсан буюу урдьдал болгон хэрэгжүүлбээс зохистой зүйл юу юу болж байгааг сайн мэдэж байжээ. Тиймээс ч тэрбээр тухайн үед онцлон анхаарах зүйлийг өөрийн саналдаа тодорхой тусгасан байна.

1914 оны 5-р сарын 13-нд тэрбээр хоёр хэсэг санал өргөсний нэг нь найман зүйлтэй нөгөө нь дөрвөн зүйлтэй байлаа. Улс төрийг засан төвхнүүлэх учрыг дөрвөн

зүйлт саналдаа тусгаж, маш нарийвчлан тайлбарлажээ. Тухайлбал: улс төрийг засах ёс нь гурван зүйлээс бүрддэг эдгээр нь юу юу вэ гэвэл 1-рт: << сургаал соёл буюу их мөнх хууль мөн (Жич: энд өгүүлж буй их мөнх хууль гэдэг бол улсын гол хууль буюу үндсэн хууль гэсэн санааг илэрхийлж буй бололтой) . Энэ бол хэзээ ч халж үл болох зүйл. 2-рт: Засгийн ёс буюу. Энэхүү ёс нь улирах цагийн эрхээр эс тохирох аваас хуучирсаныг нь халж шинэчилж болно. 3-рт: Цааз хууль буюу. Үүнийг цагийн аясаар шинэтгэх буюу татаж өөрчилж болно. Энэ гурван зүйл бол <<улс төрийн засгийн ёсны маш чухал бөгөөд маш эрхэм>> зүйл учир үүнийг хэрхэвч онцгойлвоос үл болно гээд хууль цаазыг хэрхэн засаж залруулан боловсруулах учрыг тогтож тайлбарласан байна. Сайн үйлийг хөгжүүлэх муу зүйлийг ариутган засахын тулд цааз хуулийг өөрчлөн шинэтгэх нь улс орон бүрд нэгэн адил төстэй нийтлэг шинжтэй боловч орон бүхэнд яг ижил байдаггүй . Энэ нь хоёр зүйлээс шалтгаалдаг. Үүнд: 1-рт үндэстэн бүхний язгуурын ёс суртахуун адилгүй. 2-рт: улс бүхний хэв хууль өөр өөр байдаг учир эдгээрийг анхаарахгүйгээр хууль цааз боловсруулах боломжгүй гэдгийг сануулжээ.

Дандаагийн энэ санал өргөж байх үед Монголын төр засаг гол хуулиа буюу Монгол улсын хууль зүйлийн бичгийг эзэн хааныхаа зарлиг болгосны дагуу бэлтгэж байсан учраас тэрбээр улсын гол хууль боловсруулахдаа улс орныхоо байдлыг анхаарахын сацуу олон улсын нийтлэг жишгийг заавал харгалзах учиртайг Улсын хуралд ийнхүү тайлбарлан өргөсөн нь лавтай .

Дандаа энэ тухай өгүүлэхдээ Манжийн төрөөс монголыг захирахад зориулан боловсруулсан хуульд монголын хэв суртлыг харгалзсан байдаг боловч тэрхүү хуулийг Монгол улсад яг хэвээр нь уламжлан шийтгүүлэх боломжгүй. Учир юу гэвээс монголчууд тусгаар улс болон оршин тогтносон атлаа хэрэг шүүж таслах заалт нь тодорхой бус битүүлэг, бүрэн бусаас гадна зарим зүйл анги нь нэгэнт цаг үеэ өнгөрөөсөн Манжийн үеийн хуучин хуулийг хэрхэвч хэрэглэж болохгүй. Хэрэв хуучин хууль хэрэглэх юм бол монголын төр харь улс гүрнүүдтэй харилцах талаар ямар зорилго зарчим баримтлах тухайд чиг хандлага болох зүйл Манж хуульд огтхон ч байхгүй гэдгийг анхааруулжээ.

Улс орны гадаад харилцаа бол нэн чухал маш эрхэм бөгөөд хэцүү зүйл учраас энэ талаар онцгой болгоомжтой хандах ёстой хэмээн дуртган сануулаад, дэлхийн олон улсын хуулиудаас Японы хууль нилээд чамбай бөгөөд гол гол асуудлыг <<бүрнээ хураангуйлан багтаасан мэт тул>> түүнийг сайн судалж санаа авах зүйлийг нь монголын хуульд тусгаж чадвал<<сая алдагдахгүй>> хууль боловсруулж болно гэсэн санаагаа Улсын хуралд уламжлаад, өөрийнхөө энэ саналыг Богд эзэн хаанд дамжуулан айлтгахыг хүсэн мэдүүлсэн байна. (А.Ф.1-1-9)

Улсын хурлын байнгын ажил эрхэлсэн түшмэл энэхүү саналыг хүлээн аваад Доод хурлаар хэлэлцүүлсэн бөгөөд тус хурал << үүнийг Дээд хуралд толилуулан гүйцэтгэн шийтгүүлэхээр хэлэлцэв>> хэмээн цохолт хийжээ. Харин Дээд хурлаар хэлэлцээд ямар шийдвэр гаргасан ба Дандаагийн хүссэний дагуу энэхүү саналыг Богд хаанд танилцуулсан эсэх нь мэдэгдэхгүй байна. Уул саналыг ажиглахад Дандаа бол төр ёс хууль цаазны ухаанд нилээд нэвтэрхий боловсорсон ба олон орны төрийн гол гол хуулийг уншиж хооронд нь жишин харьцуулаад тэдгээрийн алинаас нь чухам манай монголчууд үлгэр дууриал санаа авах боломжтой вэ ? гэдгийг Улсын хуралд санал болгосон нь илэрхий байна.

Түүний хоёр дахь санал нь улс орны эдийн засаг аж ахуйг хөгжүүлэхэд төрөөс юу юуг анхаарах вэ? гэдгийг Улсын хуралд хураангуй байдлаар толилуулсан байна.

1914-оны IX сарын 8-аас 1915-оны VI сарын 7-нд буюу бараг 9 сарын турш Хиагтад үргэлжилсэн ДИУ, Хаант Орос ,Монгол гурван улсын гэрээний үед Монголын эрх баригчид төрийн түшээд төдийгүй эгэл ард хүртэл улс орныхоо тусгаар тогтнолын хувь заяанд сэтгэл зовж байлаа. Чухам тэр үед буюу 1914 оны X сарын 20-нд Дандаа улсын хуралд санал өргөж төрийн гадаад бодлого бол нэн <<бэрх будилаантай бөгөөд үргэлж хэрэг явдал дэгдээх нь ... аймшигтай>> (Ф А 1-1-9) хэмээн анхааруулаад аливаа

орон<< гадаад улсад итгэн түшиж хамгаалуулах хэмээх>>-ийг эдүгээ цагт маш цээрлэх (болгоомжлох гэсэн санааЗ.Л.) болжээ. <<Учир юун хэмээвээс>> тэр орон нь хамгаалах нэрийдлээр тухайн улсын <<гадаад холбогдлын эрхийг аваад дараа болбаас цэрэг боловсруулах эрх ба эд (эдийн З.Л.) засгийн эрх, төмөр замын зэргийн эрхүүдийг улмаар эзэлсээр даруй мөхөөхөд хүрмүй. Эдүгээ энэ цагийн мөхсөн олон улсын учрыг хянаваас үүнээс эс гарсан нь үгүй>> гэж сануулжээ. 1913 оны XI сарын 5-нд ДИУ, Орос хоёр Бээжин хотноо нэгэн тунхаглалд гарын үсэг зурж <<Их Оросын Хаант Улсын Засгийн газраас дэвшүүлсэн ерөнхий журмыг үндэс болгохыг ДИУ-ын Засгийн газар>> (Орос, Хятадын гэрээ хэлэлцээрүүдийн эмхтгэл. Нэгдүгээр хэсэг (1689-1949) УБ. 2001. 122 дахь тал) зөвшөөрч, Монголыг ДИУ-ын эзэн эрхийг хүлээсэн автономит эрхтэй улс болгохоор тохиролцсон бөгөөд үүнийгээ Хиагтын гэрээгээр Монголд тулган хүлээлгэхийг тэд хичээж байлаа. Ийм нөхцөлд манай Монгол аль ч улс оронтой харилцахдаа маш болгоомжлох ёстой. Ялангуяа ямар ч улсын бүх талын хамгаалалд шүтэж хэрхэвч болохгүйг цохон заасан байна.

Дандаа өөрийнхөө энэ анхааруулгыг бараг тайлбарлаагүй боловч хүчирхэг зарим улс бусад бага буурай үндэстнийг хэрхэн ямар аргаар эрхшээлдээ оруулдгийг хэд хэдэн орноор төлөөлүүлэн өгүүлжээ. Тухайлбал Франц улс ёс суртахууныг гол болгож, бусад орныг эрхшээлдээ оруулахыг хичээдэг. Тиймээс ч анх эхэлж аль нэг улсад хандахдаа <<адбиш зөөлөн найртайгаар уулзаж, их бэлэг сэлт хүргэж бариад>> тухайн улсын гэнэн цайлган бөгөөд <<маанаг(гэнэн итгэмтгий-З.Л.) ардыг гэсгээн сургаж сайнд жолоодсугай хэмээн хэлэлцэж гэрээ бичиг байгуулаад, бас хамгаалах тэмдэгт аваад тэр улсын харьяат газар >> нутгаар явж, өөрийнхөө <<суртахууны ёсоо тархаамуй. Их төлөв нь үгээгүү буурай амь тэжээж үл чадах тийм ардад мөнгө зоосоор туслаж түүнийг суртахууны харьяат шавь болгон оруулж аваад дараа нь бас өртөг мөнгө өгч аж ахуйг тэтгэн тэжээлгэхээс гадна>> өөртөө итгэлтэй болсон хүмүүсээ элдэв зүйлээс хамгаална. Ингэсээр эцэст нь тухайн улсыг эрхшээлдээ оруулж авдаг юм. Манж Дайчин улс <<доройтож мөхсөн нь их төлөв цөм>> ийм <<шалтгаанаас болсон бөлгөө>> гээд аль ч улсын ард иргэд хэвшиж дадсан уламжлалт ёс суртахуунаа алдвал тухайн орон бусдаас хараат болоход тун ч дөхөмтэй. Чухам иймээс би << суртахууны сургаал бичиг зохиосон ба суртахууны яам байгуулмуй хэмээсэн нь үүний учир болай>> хэмээн дуртган сануулжээ.

Ямар нэгэн улс орон бусдын эрхшээлд автаж, түүнээс хараат болох аваас <<гашуун зовлонд нэрвэгдэж>> хүн зон нь үлэмж шаналж зүдрэх болдог юм шүү гэдгийг тодорхой жишээгээр нотлон бичсэн байна.Тухайлбал Япон, Франц, Англи улсууд Солонгос болон бусад зарим оронд ноёрхлоо тогтоомогц тэнд элдэв янзын дэглэм хэвшүүлж хатуу чанга хууль дагаж шийтгүүлэх болсноор хүн ард нь тэсэхүйеэ бэрх болж туйлдан эрсдэж байгааг товч өгүүлсэн байна. Ялангуяа Англи улс эртний түүхтэй <<Энэтхэгийн орны таван их аймаг улсыг мөхөөж (эзлэж З.Л.) эзний нэгэн угсааг бүгдийг барьж хүн амьтангүй далайн хойгт хориод түүний улс иргэнийг зовоох нь хэдүй урьдаас баахан хөнгөн боловч>> ард иргэдийг нь <<алс хол хэдэн түмний газарт цэрэг>> болгон <<явуулахаас гадна аливаа хот байгуулах ба зам засах, гол засах тэргүүтэй гашуун албанд>> зүтгүүлэн зовоож байдгийг дурджээ.

1911 онд төрийнхөө тусгаар тогтнолоо сэргээснээс хойш монголын эрх баригчдын зарим нь Хаант Оросыг бусад улсаас илүү дотночлон манай монголыг <<Орос улс өмгөөлөнө, хамгаална биз>> (О.Батсайхан монголын тусгаар тогтнол ба Хятад,Орос, Монгол гурван улсын Хиагтын гэрээ (1911-1916)УБ. 2002. 119-120 дахь талд) хэмээн итгэх хандлагатай байсан билээ. Гэвч сүүлдээ Хаант Орост итгэж найдах нь харьцангуй буурч, зарим нөлөө бүхий сайд ноёд түшмэд Японыг сонирхож түүнд хандахыг хичээсэн боловч уг зорьсноо хэрэгжүүлж чадаагүй юм . Чухам ийм эгзэгтэй үед Хаант Орос Монголд эдийн засгийн талаар тун ч өргөн эрхтэй болж монголчууд хүртэл

орон нутгийн гааль төлдөг байхад орос худалдаачид ямар ч гааль татвар хураамжгүйгээр монголын аль ч нутагт дураараа зорчиж худалдаа, үйлдвэрлэл эрхэлж байлаа. Ингэж монголд Хаант Оросын нөлөө хятадаас илүүтэй болжээ. Иймээс Хаант Орос өөрийн ноёрхлоо тогтоосон оронд ямар байдлаар хэрхэн ханддагийг монголчуудад, төрийн эрх мэдэлтнүүдийн гол чуулга болсон Улсын хуралд танилцуулахыг Дандаа анхаарсан бололтой. Тэрбээр бичихдээ Орос улс << Полон (Польш ? З.Л.) улс хэмээхийг >> эрхшээлдээ аваад, тус орны хүн амын << жаран наснаас янагш (доош З.Л.) эр, эмийг бүрнээ Хойд мөсөн далайн хөвөөнд нүүлгэж аваачаад хоёр зэрэг хүрээ байгуулаад эр, эмийг хоёр тийш салгаж хорьжээ. Энэ нь нэн илүү аюумшигтай бөлгөө. >> гэжээ. Энд дурдсан зүйлээ Дандаа ямар нэгэн сурвалжаас авсан нь лавтай байх, хэдийвээр энд хэтрүүлсэн зүйл байгаа нь үзтэл илэрхий боловч Хаант Орос бол болгоомжилбоос зохилтой орон мөн. Түүний өмгөөлөл хамгаалалд багтах гэж хичээх нь тийм ч сонгосон шийдэл бус гэдгийг Улсын хурал << хянан сэргийлэх нь >> чухал хэмээн сануулжээ.

Дандаа энэ саналыг яагаад өргөснөө учирлан тайлбарлахдаа: хүчирхэг улсуудын башир аргад хууртан автаж мөхсөн улс << дөч илүү >> байна. << Иймийн тул гадаад >> улсын << хэцүү аюумшигтай бөгөөд зальхай зусар аргад мэхлэгдүүзэй хэмээн хичээн сэргийлж урьдаас тосож бэлтгэх болов уу хэмээн аливаа учрыг хэдэн зүйл дараалан гаргавай >>. Үүнийг <<сайд нар байцаан толилоод үнэхээр зөвшөөрөх мэт болбаас даруй мэдүүлсэн ёсоор явуулах ажаамуу. Үүний тул өргөн баривай >> хэмээжээ. Монголын ихэс дээдэс, Улсын хурал Дандаагийн өргөсөн энэхүү саналыг анхаарч Хиагтын гэрээнд оролцож байсан төлөөлөгчдөдөө сануулж байсныг шууд нотлох сурвалжийг би олж үзсэнгүй. Гэвч анхаарч харгалзсан нь лавтай буй за. Тэрхүү гэрээнд манай монголын Засгийн газраас томилогдон очсон төлөөлөгчид улс орныхоо эрх ашгийн төлөө үнэнхүү хичээж байсан боловч хоёр хэт их гүрний эвсэн хуйвалдсан шаардлагыг няцааж чадаагүй нь түүхэн үнэн билээ.

Дандаа төр улсыг төвшитгөн засах ёс, төрийн гадаад бодлогын тухайд холбогдох тун чухал асуудлаас гадна монголын << эдийн эрх ашгийг (аж ахуй эдийн засгийг З.Л.) >> хэрхэн хөгжүүлэх ямар зарчим баримтлах юу юуг түлхүү анхаарах ёстойг тодорхойлж улсын хуралд уламжлан толилуулсан найман зүйлт санал бас байдаг бөгөөд тэр тухай товч өгүүлэв. Тэрбээр 1914 оны 5-р сарын 13-нд бичсэн уул саналынхаа эхэнд аль ч улс оронд үндэсний мөнгөн тэмдэгт, зоос тун чухал учир холбогдолтой << улсын эрдэнэ мөн >> (ФА 1-1-9) иймээс тусгай газар байгуулж мөнгө, зэс, гуулиар улсын мөнгөн тэмдэгт үйлдэж дэлхий дахинд тархааж мэдэгдвээс зохино хэмээн тэмдэглэжээ.

Мөн нэгэнт зоос гаргах болбаас түүний бүх асуудлыг эрхлэн хариуцах <<улс гэрийн мөнгөний пүүс >> (банк З.Л.) байгуулж, сая лангийн өртөг бүхий << пиу (үнэт З.Л.) цаас гаргах болбаас улс гэрт гурван зүйлийн тус буй амуй >>. Тухайлбал 1-рт аливаа хүн заавал бэлэн мөнгө хэрэглэхгүйгээр арилжаа худалдаа хийхэд << амар хялбар болно >>. 2-рт << гадаад улсад өрдөхгүй бөгөөд улс гэрийн аливаа хэрэглэлд асар гачигдахгүй болно >> хэмээн үндэсний мөнгөн тэмдэгттэй болж чадвал харь улсаас зээл авахгүй байх нэг нөхцөл бүрдэх боломжтой хэмээн үзжээ. 3-рт << эдийн засгийн эрх бусдад алдагдах хэрэг үгүй болно >>. Өөрөөр хэлбэл улсын мөнгөн тэмдэгт нь эдийн засгийг хөгжүүлэхэд үлэмж нөлөөтэй хэмээн сануулсан байна.

Нийслэл Хүрээнээс эхлэн улсын бүх хот суурин бусад газар худалдаа эрхэлж буй хятад иргэдээс хураах татварт чанд хяналт тавьж тэдний элдвээр мэхлэн залилж байгааг таслан зогсоох талаар тэрбээр анхааруулжээ. Тэр үед монгол нутагт худалдаа үйлдвэр эрхэлдэг хятадууд янз бүрийн аргаар гааль татвараас зайлсхийж улсын сан хөмрөгт хохирол учруулах нь түгээмэл байсан билээ. Иймээс ч Дандаа энэ тухай асуудлыг хөндсөн нь мэдээж.

Монгол улс эдийн засгаа өөд татахад газар тариалан зохих нөлөөтэйг Дандаа анхаарч энэ тухай улсын хуралд санал бодролоо өргөн танилцуулсан байдаг бөгөөд энэ тухай өгүүлбэр . Монгол нутагт оршин тогтнож байсан эртний овог аймаг, улсуудаас эхлээд Манжийн эрхшээлийн төгсгөл хүртэлх бүхий л хугацааны туршид тариалан эрхэлж амь зуулгадаа тус нэмэр болгодог хүмүүс цөөнгүй байлаа. 1910 оны орчим үйлдсэн бололтой бүрэн бус нэгэн бүртгэлээс үзвэл Гадаад Монголын 240 гаруй өрх байнга тариалан эрхэлж байжээ. Энэ нь хэдийгээр үл ялих мэт боловч монголчуудын зарим нь малаас гадна тариалангаар амь зуулгаа залгуулж байсны нотолгоо мөн. Тиймээс ч Монголын төр засаг 1913 онд шийдвэр гаргаж, сангийн буюу улсын тариаланг тусгай хүмүүсээр эрхлүүлж тэдний хэрэглэх анжис, сам буюу борной , тарих үрийг улсаас олгож хураасан ургацынх нь гуравны нэгийг улсын санд авч, мөн гуравны нэгийг нь дараа жил тарих үр болгон нөөцлөж үлдсэн 30 гаруй хувийн талыг буюу нийт ургацын 16,5 хувийг харьяат хошууны хэрэгцээнд үлдсэн 16,5 хувийг тариалсан хүнд << аж төрөх хувь болгон >> (Зарлигаар тогтоосон Монгол улсын хууль зүйлийн бичиг. УБ. 1995 61 дэх талд) хууль ёсоор олгож байлаа.

Хэдийвээр төр, засгаас тариаланг чухалчлан анхаарч, нилээд арга хэмжээ авч байсан боловч төдийлөн ашиг өгөхгүй буюу голдуу алдагдалтай байлаа. Энэ нь тариалан эрхлэх арга бүдүүлэг, бүх ажлыг биеийн хүчээр гүйцэтгэж байсан нь нөлөөлсөн байх. Түүнээс гадна байгаль цаг уур болон дорвитой зохион байгуулалт дутаж байсныг хэлэх хэрэгтэй. Монголын ихэнх хошуунд тариалан эрхлэгчид маш цөөхөн байсан бол халхын төв нутаг Сэлэнгийн хөндий, Ховд, Увс, Алтайн хязгаарын зарим хошууны гол мөрөн зарим булаг шандны орчимд харьцангуй олон өрх тариалан эрхэлж талбай, усны хүрэлцээ хомсдох тохиолдол ч мөн ховор бус байсан нь тариалангаас тогтвортой ургац авахад сөргөөр нөлөөлж байжээ.

Ийм байдлыг гярхай хичээнгүй түшмэл Дандаа ажин мэдээд, Улсын хуралд тодорхой санал өргөж тариалан хөгжүүлэхийн тулд юу юу анхаарах ёстойг цохон тэмдэглэжээ. Түүний бичсэнээр бол хамгийн түрүүнд олон хошууны нутгийг сайтар шинжиж чухам хаана тариалан эрхлэх боломжтойг олж тогтоох хэрэгтэй. 2-рт хэрэв тариалан эрхлүүлэх аваас урьдын адил хөлсний хятад тариачид дээр бус харин << өмнө хязгаарын монголчуудыг (өвөрлөгчдийг З.Л.) элсээн тариулбаас болно>>.3-рт тариалан эрхлүүлэхдээ хошуу тутамд ялгаатай хандаж нутаг дэвсгэрийнх нь хэмжээг харгалзан ямар ч хошуунд тариалах өрхийг нэг зуугаас хэтрүүлэлгүй 60, 30-аар буюу нэг хошуунд дунджаар 60 өрх байх нь хамгийн зохистой гэж үзжээ. 4-рт тэрбээр газар тариалангийн бүх ажлыг аль болохоор хөнгөвчилж << оньст хүрдний сав зэвсгээр үйлддэг болбаас тарианы ашиг их л бадрах болно >> хэмээн механикжуулах, техник нэвтрүүлэхийг нэн чухалчлан тэмдэглэсэн байна. Ийнхүү Дандаа тухайн үед газар тариалангийн үр өгөөжийг дээшлүүлэхийн тулд монголын төр засаг зайлшгүй харгалзууштай чухал зүйлийг хөндөн санал болгожээ. Тухайн тэр үед монголчууд тариаландаа техник нэвтрүүлэх нь өнөөгийн өндөрлөгөөс эргэцүүлэхэд хэзээ ч үл бүтэх хоосон мөрөөдөл мэт санагдаж болзошгүй . Гэвч тэр үед дэлхийн олон орон хөдөө аж ахуйдаа, ялангуяа газар тариаландаа янз бүрийн төхөөрөмж техник хэрэглэж ашиг орлогоо нэмэгдүүлж хүн ардаа хэрэгцээт үр тариа хүнсний ногоогоор хангаж байсныг түшмэл Дандаа сайтар мэдэж, тийнхүү Улсын хуралд санал болгосон нь лавтай.

Улсын хурал Дандаагийн энэ саналыг ажил хэрэгч байдлаар анхаарсан эсэх, мөн энэ талаар ямар нэгэн ажил санаачилсан эсэхийг би тодруулж чадсангүй. Харин газар тариалан улсын санд ямар ч ашиг өгөхгүй байсны улмаас 1918 онд Монголын Засгийн газрын санал болгон айлтгасны дагуу Богд хаан зарлиг буулгаж албаны буюу сангийн тариаланг цаашид үргэлжлүүлэхээ зогсоосон байна. Гэвч айл өрхүүд, жас жав, гадаадын харьяат иргэд өөрийнхөө тариаланг тасралтгүй үргэлжлүүлсээр байлаа.

Дандаа найман зүйлт саналынхаа 5-рт нь өгүүлэхдээ Монголын төр засаг газрын хэвлийнхээ үнэт ховор баялаг-алт, мөнгө, зэс, эрдэнийн чулуу, усан болор ба аж ахуйн хэрэгцээний чухал зүйл болох чулуун нүүрс зэргийг судлан шинжилж << гадаад улсад

өгөхгүй монголчуудын олон баян ардыг хөхиүлж>> зардал төсөв гаргуулан << оньст хүрдний сав зэвсгээр үйлдүүлэх болбаас ... ашиг их л бадрах болно>> хэмээн дуртган сануулжээ. Үүнээс үзвэл Монгол Улс эдийн засгаа хөгжүүлэхэд албан татвар, гааль, газар тариалангаас гадна ашигт малтмал тун ч учир холбогдолтой. Иймд түүнийг шинжлэн олж, өөрийн хүчээр ашиглах нь зүйтэй. Тэгэхдээ зарцуулах хөрөнгийн эх үүсвэрийг олохын тулд үндэсний баячуудаа дэмжин урамшуулж чадвал тийм ч хэцүү бус гэж тэрбээр үзсэн нь илэрхий байна. Мөн Дандаа энэхүү баялгийг ашиглахдаа газар тариалантай адил хөдөлмөр хөнгөвчлөхүйц техник буюу << оньст хүрдний сав зэвсэг>> хэрэглэх нь зайлшгүй чухлыг онцлон дурджээ.

Монгол нутаг өвс ургамлаар элбэг боловч ой мод төдий л их биш учраас тун хямгатай ашиглахыг Дандаа Улсын Хуралд санал болгож << модыг дэмий огтлохыг >> эрс цаазлаж чухал хэрэгцээтэй зүйлд тухайлбал барилгын ноён нуруу, цонх, хаалга зэрэгт мод хэрэглэе. Харин хашаа хороо барих түлээ түлшинд мод хэрэглэхийг << чангалан цаазлаад >> ой модоо << өнө удаан тасаршгүй хэрэглэхэд бэлтгэвээс зохино >> гэж сануулсан байна. Мөн тэрбээр монгол нутагт шаврын уурхай нээж << ваар тоосго шатааж орд харш ба хот балгас, сүм суварга... байшин хороо хашаа барихад >> хэрэглэвээс мод хэмнэж арвилахад тустай төдийгүй барилгын ажлыг << амар хялбар>> болгоход ч дөхөмтэй гэж саналынхаа 6,7-р зүйлд товчхон дурдаад түүнийгээ дэлгэрүүлж тайлбарласангүй.

Дандаа түшмэл саналынхаа төгсгөлд нь чулуун нүүрсний тухай тусгайлан өгүүлжээ. Тэрбээр бичихдээ чулуун нүүрсийг гурван зүйлд голлон хэрэглэх нь зүйтэй. Тухайлбал << оньст хүрдний савын хороо>>, << гал (галт З.Л.) тэрэг >>, << олны түлш >> зэрэгт ашиглах нь зүйтэй гэжээ. Энд өгүүлж буй << оньст хүрдний савын хороо >> гэдэг нь уурын хөдөлгүүрт машин механизм буюу цахилгаан эрчим хүчний үйлдвэрийг зааж буй бололтой. Харин төмөр замын бух тэрэг ба айл өрхийн түлшинд чулуун нүүрсийг ашиглах хэрэгтэй гэсэн нь ойлгомжтой байна. Дандаа энэхүү найман зүйлт саналынхаа эцэст << эдгээр зүйлчлэн мэдүүлсэнийг Их (Улсын З.Л.) хурлаас байцаан толилж хэрэв зөвшөөрөх мэт болбаас улам давшуулж Богд эзэнтнээ айлтган гуйн мэдүүлсэн ёсоор явуулах ажааму >> хэмээн хичээнгүйлэн хүссэн байна.

Би өмнө өгүүлснээ дахин давтахгүйгээр тэмдэглэхэд Дандаагийн эдгээр гурван удаагийн саналыг Улсын Хурал хир зэрэг анхаарсан нь тодорхойгүй боловч 1910-аад онд батлан дагаж шийтгүүлсэн << Зарлигаар тогтоосон Монгол улсын хууль зүйлийн бичиг>>, << Монгол улсын хөрөнгийг захирах газрын дүрэм >>, << Монгол улсын уурхайн дүрэм>> зэрэг төрийн албан ёсны шийдвэрт түүний дэвшүүлсэн саналын нилээд нь туссан бололтой байна. Жич: Дандаа өөрийн туурвисан << Эрдэнэт шастир>>, << Шинэ засгийн ёс>> зэрэг бүтээлдээ дээрхи саналуудынхаа үндсэн санааг нилээд тогтож тэмдэглэжээ. Үүнтэй холбогдуулж хэлэхэд монголын нэрт эрдэмтэн энэ хүний үзэл баримтлал, бүтээл туурвилыг цаашид тусгайлан судлах нь олон талын учир холбогдолтой.

Тэрбээр Засгийн Газар зөвлөх түшмэлийн алба хашиж ахуйдаа ерөнхий сайд Т.Намнансүрэнтэй ажил төрлийн тун ч ойр холбоотой байсан байж магадгүй. Тухайлбал Дандаа 1915 оны өвөл Нийслэл Хүрээнээс хэдэн харчин эр дагуулж, тэмээ хөлөглөн хөр цасны хүйтэн жавар, алс холын бартаат замын бэрхшээлийг үл ажран Баргын нутагт хятадын хар цэрэгтэй дайтаж байсан гүн, шударга баатар Бавуужавтай нүүр тулан ярилцахдаа << монгол угсааны хэргийг шинэ үүсгэн гавъяагаа төгсгөхгүйгээр өөр зуураа зэвсэг хөдөлгөхийг зүй хэмээвээс болом уу? Сайд бүгд улсаа тэрслэхийг зөв хэмээвээс болом уу? Гүн Та байлдахыг байж хойш эгэхийг хүсмүй >> . (*З.Лонжид, Ж. Өлзий. Шударга баатар Бавуужав. УБ. 2002 20 дахь талд*) хэмээн ятгасан болов ч түүний саналыг Бавуужав огт хүлээж аваагүй байна.

Дандаа ийнхүү Барга руу явж Бавуужавтай уулзсан нь миний бодоход Монголын эрх баригчид тухайлбал Т. Намнансүрэнгийн даалгаврыг биелүүлсэн хэрэг байж ч болох

юм. Ингэж таамаглахын учир гэвэл Т.Намнансүрэн 1915 оны эхээр Бавуужавыг дайтахаа зогсоож өөрийн хүссэн дуртай нутагтаа буюу Монгол улс. Өвөр Монголын хаана нь ч амар тайван сууж аж төрөхийг санал болгон бичсэн захидлын хуулбар сурвалж бичгийн сан хөмрөгт үлдэж хоцорчээ.

Ном зүй

1. Батсайхан.О. Монголын тусгаар тогтнол ба Хятад, Орос, Монгол гурван улсын 1915 оны Хиагтын гэрээ (1911-1916). УБ. 2002
2. Зарлигаар тогтоосон Монгол улсын хууль зүйлийн бичиг .УБ. 1995
3. Лонжид .З. , Өлзий .Ж. Шударга баатар Бавуужав .УБ. 2002
4. Орос-Хятадын гэрээ хэлэлцээрүүдийн эмхтгэл. Нэгдүгээр хэсэг. (1689-1949 он) УБ.2001
5. Үндэсний төв архив ФА-1,Т-1,ХН-9
6. Хохлов А.Н. Новая публикация документов о посольстве Ю. А. Головкина в Китай-прочная основа для новых архивных поисков и находок. –Архивоведение и источниковедение отечественной истории. Проблемы взаимодействия на современном этапе. Доклады и тезисы выступлений на второй Всероссийской конференции. 12-13 марта 1996 г. М 1997

“The State Great Khural and scholar Dandaa.”

Resume

By prof. Z.Lonjid (Ph.D.)

Anew subjected to Mongolia in 1911 Mr. Dandaa was the officer and scholar. He knew several foreign languages and studied Mongolian and World History. He wrote two books.

He has been submitting several times proposals to the State Great Khural. I would like to touch briefly in this article the proposals could contribute to the development of the country.